




NATIONAL RESEARCH AND
CONSULTING CENTER CO. LTD



MONGOLIA-JAPAN CENTER FOR
HUMAN RESOURCE DEVELOPMENT

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС-2021.II



УЛААНБААТАР ХОТ
2021 оН

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	2
ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКСИЙН СУДАЛГАА, ТООЦОХ АРГАЧЛАЛ	3
ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС ҮНЭЛЭХ УЛИРЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	6
1. Хэрэглэгчийн итгэлийн индекс	6
2. Үнийн түвшин, ханшны хүлээлт	10
3. Худалдан авалтын төлөвлөгөө	12
4. Мөнгөн хөрөнгө хадгалах хэлбэр, зээлийн эрэлт	14
5. Санхүүгийн итгэл	15
ДҮГНЭЛТ	17

ТАНИЛЦУУЛГА

ЭН-АР-СИ-СИ ХХК болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс “Хэрэглэгчийн итгэлийн индекс, эдийн засгийн өнөөгийн байдал” улирал тутмын тайланг танд хүргэж байгаадаа баяртай байна. Энэхүү тайланг 2009 оноос хойш хийгдэж байгаа улирал тутмын болон жил бүрийн Хэрэглэгчийн итгэлийн индекс үнэлэх түүвэр судалгааны тоон мэдээлэлд үндэслэн бэлтгэдэг.

“Хэрэглэгчийн итгэлийн индекс” нь эдийн засгийн ерөнхий байдал болон өөрсдийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. “Хэрэглэгчийн итгэлийн индекс” болон түүнтэй төстэй индексүүдийг АНУ, Англи, Австрали, Тайланд, Украин, Хонг-Конг, Хятад, Чех, Япон зэрэг олон улс оронд тооцож гаргадаг бөгөөд энэ нь эдийн засгийн ерөнхий байдлыг харуулдаг гол үзүүлэлтүүдийн нэг юм. Хүмүүсийн хэрэглээ, хадгаламж нь тэд өөрсдийн цалин, орлогын тогтвортой байдлын талаар хэр зэрэг итгэлтэй байгаагаас ихээхэн хамаардаг. Тухайлбал, эдийн засгийн байдал сайжрахын хирээр хэрэглэгчдийн итгэл дээшилбэл бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ. Харин эдийн засгийн байдал муудахын хирээр хэрэглэгчдийн итгэл буурвал хэрэглэгчид хэрэглээгээ багасгана.

Монгол Улсад бусад орнуудын нэгэн адилаар хувийн хэрэглээний зардал ДНБ-ий хамгийн том бүрэлдэхүүн хэсэг байдаг бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн хамгийн том худалдан авагч нь монголын нийт өрхүүд юм. ҮСХ-ны мэдээлснээр 2019 онд өрхийн хэрэглээ ДНБ-ий 62 хувийг эзэлж байна. Монголын “Хэрэглэгчийн итгэлийн индекс” нь эдийн засгийн ерөнхий дүр төрхийн талаарх мэдээлэл өгдөг үзүүлэлтүүдийн нэг болохын хувьд улсын болон хувийн байгууллагуудад эрэлт, хэрэгцээтэй байна.

МУИС-ийн ЭЗС-ийн эрдэмтэн, судлаачдын баг анх удаа 2009 оны 4 сард Нээлттэй Нийгэм Форумтай хамтран Улаанбаатар хотод “Хэрэглэгчийн итгэлийн индекс”(ХИИ) судалгаа хийж, үр дүнг тайлан болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон. Уг судалгаа түүнээс хойш тасралтгүй 11 жил хийгдэж байна.

Энэ удаагийн тайланд 2021 оны 2-р улирлын судалгааны үр дүн болон КОВИД-19 цар тахлын нөлөөний талаарх судалгаа багтаж байна. Энэ улирлын судалгааны асуулгыг 2021 оны 6-р сарын 22-ны өдрөөс 7-р сарын 8-ны өдрийн хооронд авлаа.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКСИЙН СУДАЛГАА, ТООЦОХ АРГАЧЛАЛ

Улирал тутам улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар хийгддэг энэхүү судалгаа нь Хэрэглэгчийн итгэлийн индексийн үнэлгээнд голлон анхаардаг.

“Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийг хэмжих, өрхийн шинж чанарыг тодорхойлох асуулга нь эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж, ойрын ирээдүйн өөрчлөлтийн талаарх хүлээлт, хэрэглэгчийн худалдан авалтын хандлага, үнийн түвшний өөрчлөлтийн таамаглал болон өрхийн шинж чанар гэсэн 5 бүлгээс бүрдэнэ.

А. Эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх өрхийн үнэлгээ

Энэ хэсгийн зорилго нь иргэд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг гаргах бөгөөд уг хэсэг нь ажил эрхлэлт, бизнесийн нөхцөл, удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлтийн өнөөгийн байдалд өрхийн өгч буй үнэлгээ болон өрхийн санхүүгийн байдалд нэг жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийн талаарх нийт 4 асуултаас бүрдэнэ.

В. Ирээдүйд эдийн засагт гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт

Энэ хэсэг нь иргэд бизнесийн нөхцөл, ажил эрхлэлт, орлогод ирэх 6 сарын хугацаанд гарах өөрчлөлтийн талаар ямар хүлээлттэй байгааг үнэлэх зорилготой.

А, В хэсгийн асуултууд, хариултын сонголтыг олон улсад хийгддэг хэрэглэгчийн итгэлийн (хүлээлтийн) талаарх түүвэр судалгаануудад өргөн хэрэглэгддэг стандарт асуултуудаас сонгон авсан 1 А хэсгийн эхний 2 асуулт болон В хэсгийн 3 асуултын мэдээлэл нийлээд ХИИ тооцоход ашиглагдана.²

С. Ойрын ирээдүйн худалдан авалтын хандлага

Энэ хэсэгт бид өрхүүдээс ирэх 6 сарын хугацаанд орон сууц, гэр, газар зэрэг үл хөдлөх хөрөнгө, автомашин, цахилгаан бараа болон аялал жуулчлалын үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж буй эсэх талаар мэдээлэл авах юм.

Д. Үнийн түвшин ирэх 6 болон 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх тухай өрхүүдийн хүлээлт

Энэ хэсэгт бид ирэх хагас болон бүтэн жилийн хугацаанд инфляци, зээлийн хүү, төгрөгийн ханш, орон сууцны үнэ хэрхэн өөрчлөгдөх талаар өрхүүдийн таамаглалыг үнэлнэ.

Е. Өрхийн тухай мэдээлэл

Өрхийн хүн ам, нийгэм, эдийн засгийн шинж чанаруудыг тодорхойлох үүднээс өрхийн ам бүл, орон сууцны нөхцөл, ажил эрхлэлт, орлого, үл хөдлөх хөрөнгө болон боловсролын талаарх асуултуудыг оруулсан.

¹Өрхийн хэрэглээний шийдвэрт өрхийн байнгын буюу насан туршийн орлого нөлөөлдөг. Хэрвээ өрхийн байнгын орлого өсвөл тэд хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой, харин түр зуурын орлогын өсөлт нь хэрэглээнд төдийлөн нөлөөлөхгүй гэж үздэг. Байнгын орлого нь өнөөгийн болон ирээдүйн орлогоор тодорхойлогддог учраас энэ төрлийн судалгаануудад өнөөгийн болон ирээдүйн орлоготой холбоотой асуултуудыг оруулдаг.

²Conference Board, Michigan, Washington-ABC News Consumer Comfort Index MasterCard Worldwide index of consumer confidence

ХИИ-ийг тооцох аргачлал

Хэрэглэгчийн итгэлийн индексийг тооцохдоо түүвэр судалгааны асуулгын өнөөгийн эдийн засгийн байдал, ажлын олдоц, ирээдүйн эдийн засгийн байдал, ирээдүйн ажлын байрны олдоц болон ирээдүйн өрхийн орлогын тухай 5 асуултад өгсөн мэдээллийг ашиглан тооцно. Эхлээд, эдгээр 5 үзүүлэлт тус бүрийн хувьд индекс тооцох ба тооцоонд зөвхөн “сайн”, “муу” гэсэн хариултуудыг л оруулна.

$$I_i = \frac{2G_i}{(G_i + B_i)} 100$$

Энд: I_i - асуулт i -ийн индекс, G_i - “сайн” гэж үнэлж буй өрхийн тоо, B_i - “муу” гэж үнэлж буй өрхийн тоо. Эндээс үзвэл “сайн”, “муу” гэж үнэлж буй хүмүүсийн тоо тэнцүү байвал I_i нь 100 байх ба энэ үед эдийн засгийн байдал хэвийн байна гэж үзнэ. Харин 100-аас бага байвал хэрэглэгчийн итгэл муу байна, 100-аас их байвал хэрэглэгчийн итгэл сайн байна гэж үзнэ. Жишээ нь, бүх хүн сайн гэж үнэлэхэд I_i хамгийн өндөр утга болох 200 хувь гэсэн утгаа авдаг. Харин бүх хүн муу гэж үнэлж байвал 0 гэсэн хамгийн бага утгаа авна. Ерөнхий ХИИ нь эдгээр 5 индексийн энгийн дундаж юм. ХИИ-ээс гадна, өнөөгийн эдийн засгийн байдалтай холбоотой 2 индексийн дундаж болох “өнөөгийн байдлын индекс” ба ойрын ирээдүйн эдийн засгийн байдалтай холбоотой 3 индексийн дундаж болох “ирээдүйн хүлээлтийн индекс”-ийг тооцно.³


Дээр дурьдсанчлан ХИИ нь 0-ээс 200-ын хооронд утга авах ба 100-аас их бол итгэл сайн, бага бол итгэл муу байна гэж үздэг.

Энэ удаагийн түүвэр судалгаа нь дээр дурдсан үзүүлэлтүүдийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж, дээрх үзүүлэлтүүдэд сүүлийн 6 сард гарсан өөрчлөлтийн хандлагыг харах, шинжилгээ хийх боломжтойгоороо онцлог болно

Түүврийн шинж чанар

2021 оны 2-р улирлын судалгаанд нийт 992 санамсаргүй сонгогдсон иргэд хамрагдсан бөгөөд судалгаа нь Улаанбаатар хот болон 21 аймгийг хамарсан.

Зураг 1. Бүсийн тархалт



³ХИИ-ийг зарим байгууллагууд тодорхой нэг оны индекстэй харьцуулж тооцдог. Тухайлбал, АНУ-ын Conference Board гэдэг байгууллага асуулт тус бүрийн индексийг 1985 онтой харьцуулдаг ба үүний үндэслэлийг 1985 онд эдийн засаг хэвийн (хэт халаагүй, унаагүй) байсан гэдгээр тайлбарладаг.

Хүснэгт 1-д түүврийн шинж чанарыг харуулж байна. Нийт оролцогчдын 42.7% нь эрэгтэй, дундаж нас нь 41 бөгөөд 51% нь Улаанбаатарт оршин суудаг байна. Оролцогчдын 45.7 хувь нь орон сууцанд амьдардаг бөгөөд 71.4 хувь нь өрхийн гишүүнд ногдох орлого нь 200,000 төгрөгнөөс их байна.

Хүснэгт 1. Түүврийн шинж чанар

	Дундаж	Стандарт хазайлт
<i>Эрэгтэй</i>	42.7	49.5
<i>Нас</i>	41	15.0
<i>Дээд боловсролтой</i>	53.8	49.9
<i>Өндөр орлоготой</i>	71.4	45.2
<i>Орон сууцанд амьдардаг</i>	45.7	49.8
<i>Улаанбаатарт амьдардаг</i>	51	50

Оролцогчдыг нас, боловсрол, амьжиргааны түвшин болон хот хөдөө амьдардаг гэсэн хүчин зүйлээр нь бүлэглэн ХИИ тооцдог.

Насны хувьд 35 ба үүнээс залуу, 35-аас дээш настай гэж ангилсан. Нийт оролцогчдын 58.4 хувь нь 35-аас дээш насны иргэд, 41.6 хувь нь 35 болон үүнээс залуу иргэд байна.

Боловсролын хувьд доогуур болон дээгүүр боловсролтой гэж ангилсан. Доогуур гэдэгт дунд болон түүнээс доогуур боловсролтой иргэд, дээгүүр гэдэгт дээд болон техник мэргэжлийн ба түүнээс дээш боловсролтой иргэд орно. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 53.8 хувь нь дээгүүр боловсролтой, 46.2 хувь нь доогуур боловсролтой байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийг ядуу болон ядуу биш гэсэн 2 бүлэг болгон ангилсан. Эхний бүлэг буюу ядуу гэдэгт өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь 200 хүртэлх төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг, хоёрдох буюу ядуу биш гэдэгт өрхийн гишүүнд ногдох сарын орлого нь 200 мянга ба түүнээс дээш төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг оруулсан.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС ҮНЭЛЭХ УЛИРЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэ хэсэгт Хэрэглэгчийн итгэлийн индекс үнэлэх улирлын судалгааны үр дүнг танилцуулж байна. Уг судалгаа нь 2014 оноос хойш 30 дахь улиралдаа хийгдэж байгаа бөгөөд улсын хэмжээнд хэрэглэгчийн итгэлийн индексийг үнэлдэг.

1. Хэрэглэгчийн итгэлийн индекс

2021 оны 2-р улиралд Монгол Улсын хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэл бага зэрэг буурсан байна (Зураг 1.1). Энэ улиралд Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 66.4 байгаа нь жилийн өмнөхтэй ойролцоо буюу 0.4 пунктээр бага байна. Бизнесийн нөхцөл болон хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмжийг харуулдаг өнөөгийн байдлын индекс 36.8-өөс 37.8 болж бага зэрэг өссөн. Харин хэрэглэгчдийн бизнес, орлого болон хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх ойрын ирээдүйн хүлээлтийг харуулдаг хүлээлтийн индекс 86.8-аас 85.4 болж бага зэрэг буурсан байна.

COVID-19 халдварын тархалтын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөний улмаас бизнесийн нөхцөл муудсан ч ажлын олдоц сайжирсан нь хэрэглэгчдийн өнөөгийн байдлын талаарх үнэлэмжийг бага зэрэг өсгөжээ. Харин ойрын ирээдүйд ажлын олдоц муудна гэсэн хүлээлт нь хэрэглэгчдийн ирээдүйн хүлээлтийн индексийг бууруулсан байна.

Зураг 1.1. ХИИ ба түүний бүрэлдэхүүн индексүүд




Бид ХИИ-ийг хэвийн онтой харьцуулан мэдээлдэг болсон. Сүүлийн 20 гаруй жилийн макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн динамикийг шинжилж үзэхэд 2018 онд эдийн засгийн төлөв байдал хэвийн байсан гэж харагдаж байна. ХИИ-ийн улирал, улирлын утгуудыг 2018 оны ХИИ-д харьцуулан тооцсон үр дүнг Зураг 2 харуулж байна. Энэ индекс нь тухайн улиралд хэрэглэгч хэвийн он болох 2018 онтой харьцуулахад хэр өөдрөг, гутранги байгааг илэрхийлнэ. Энэ тооцсон ХИИ 100 байвал хэрэглэгчийн итгэл 2018 онтой адилхан байгааг илэрхийлнэ. Харин

100-гаас бага бол 2018 онтой харьцуулахад гутранги байгааг, 100-гаас их бол өөдрөг байгааг илэрхийлнэ.

ХИИ 2014 оны 4-р улиралд ёроолдоо хүрчээ. Түүнээс хойш хэлбэлзэлтэй ч өсөх хандлагатай байна. Өнөөгийн байдлын индекс 2015 оны 2-р улирлаас хойш буурсаар 2016 оны 2-р улиралд ёроолдоо хүрсэн байна. Түүнээс хойш тасралтгүй өссөөр 2019 оны 2-р улиралд оргилдоо хүрчээ.

Сүүлийн улиралд ХИИ индекс 6 нэгжээр буурсан байна. Үүнд хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх үнэлэмж болон ирээдүйн төлвийн талаарх итгэл аль аль нь өмнөх улиралтай харьцуулахад буурсан нь нөлөөлжээ.


Зураг 1.2. ХИИ ба түүний бүрэлдэхүүн индексүүд 2018 онтой харьцуулснаар



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, харгалзах 2018 оны индексүүдтэй харьцуулж тооцсон.

ХИИ нь макро эдийн засгийн төлөв байдалтай ойрхон хамааралтай байдаг. Зураг 1.3-д ХИИ ба эдийн засгийн өсөлтийг харуулж байна. Хэрэглэгчид өөдрөг байх үе буюу ХИИ 100-гаас өндөр байхад ДНБ-ий улирлын дундаж өсөлт 6.4 хувь байсан бол хэрэглэгчид гутранги байх үе буюу ХИИ 100-аас бага байхад дундаж өсөлт 2.5 хувь байна.


Зураг 1.3. ХИИ ба эдийн засгийн өсөлт



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, харгалзах 2018 оны индексүүдтэй харьцуулж тооцсон. Эдийн засгийн өсөлтийн тоон өгөгдлийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан: www.1212.mn.


2021 оны оны 2-р улирлын байдлаар Улаанбаатар хотод Хэрэглэгчийн итгэлийн индекс 72 байна. Өнөөгийн байдлын индекс 47, ирээдүйн хүлээлтийн индекс 88 байна. Хөдөөд хэрэглэгчийн итгэл хотынхоос бага бөгөөд дундаж ХИИ 60 байна. Харин хангайн бүсэд ХИИ 69 байгаа нь хамгийн өндөр бөгөөд хотынхтой ойролцоо байна. Төв, баруун болон зүүн бүсийн ХИИ тус тус 57, 56, 63 байна.

Зураг 1.4. ХИИ бүсээр




Зураг 1.5-д хэрэглэгчийн итгэлийн индексийг боловсрол, орон сууцны нөхцөл, орлого, хүйс болон насны бүлгээр харуулж байна. 2021 оны 2-р улиралд ХИИ орлого багатай, боловсрол доогуур бүлгийн хувьд жилийн өмнөхөөс буурсан бол орлого өндөр, боловсрол дээгүүр бүлгийн хувьд өссөн байна.

Зураг 1.5. ХИИ боловсрол, орон сууц, орлого, хүйс болон насны бүлгээр




2021 оны 2-р улиралд өрхийн санхүүгийн байдал жилийн өмнөхөөс муудсан гэж нийт өрхийн 54.2 хувь үзэж байхад, 3.6 хувь нь сайжирсан гэж хариулсан байна. Сайжирсан гэж хариулсан өрхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.8 пунктээр буурсан бол муудсан гэж хариулсан өрхийн эзлэх хувь 14.7 пунктээр өссөн байна. Зураг 6 өрхийн санхүүгийн байдлын индексийг харуулж байна.

Зураг 1.6. Өрхийн санхүүгийн байдлын индекс



Өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжгүй үе гэж 81.4 хувь нь үзэж байхад 8.5 хувь нь тохиромжтой үе гэж үзжээ. Тохиромжгүй гэж үзсэн өрхийн тоо жилийн өмнөхөөс 1.9 пунктээр өсч, тохиромжтой гэж хариулсан өрхийн тоо 3.4 пунктээр буурсан байна. Харин мэдэхгүй гэсэн хариулт өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өсчээ.


Зураг 1.7. Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдан авахад тохиромжтой эсэх



2. Үнийн түвшин, ханшны хүлээлт

2021 оны 2-р улирлын байдлаар хэрэглэгчид ирэх зургаан сарын хугацаанд инфляци 9.2 хувьд хүрнэ гэсэн хүлээлттэй байна. Хүлээгдэж буй инфляци өмнөх оны мөн үеэсээ бараг 2.5 дахин, өмнөх улирлаасаа 2 пунктээр өслөө. 2020 оны 4-р улирлын судалгаагаар иргэд зургаан сарын дараа буюу 2021 оны 2-р улиралд инфляци 6.6 пунктээр өсч 6.2 хувь болно гэсэн хүлээлттэй байв. Харин бодит инфляци 5.6 пунктээр өсч 5.2 хувь болсон. Судалгаа эхэлсэн 2014 оны 1-р улирлаас хойшхи хугацаанд ойрын зургаан сарын хүлээгдэж буй инфляцийн дундаж 3.8 хувь, харин бодит ажиглагдсан инфляцийн дундаж 2.3 хувь байна.

Зураг 2.1. Хүлээгдэж буй инфляци, 6 сар болон жилийн хугацаанд



Эх үүсвэр: ХИИ-ийн судалгаа, ҮСХ-ны мэдээллийн цахим хуудас www.1212.mn


Нэг жилийн дараах хүлээгдэж буй инфляци 11.4 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үеэсээ бараг 5 пунктээр өндөр байна. 2020 оны 2-р улирлын судалгаагаар иргэд жилийн дараа буюу 2021 оны 2-р улиралд инфляци 3.7 пунктээр өсч 6.5 хувь болно гэсэн хүлээлттэй байсан. Харин бодит инфляци 3.8 пунктээр өсч 6.6 хувь болсон.

2014 оны 1-р улирлаас хойшхи хугацаанд нэг жилийн дараах хүлээгдэж буй инфляцийн дундаж 5.8 хувь, харин бодит ажиглагдсан инфляцийн дундаж түвшин 4.8 хувь байсан.

Энэ улирлын судалгаагаар хүлээгдэж буй инфляци Улаанбаатар хот болон хөдөөд бага зэрэг ялгаатай байна. Ирэх зургаан сарын хүлээгдэж буй инфляци Улаанбаатар хотод 9.5, харин хөдөөд 8.8 хувьтай байна. Нэг жилийн хүлээгдэж буй инфляци Улаанбаатар хотод 12.2 хувь, хөдөөд 10.6 хувьтай байна.

2021 оны 2-р улирлын байдлаар хэрэглэгчдийн 39.2 хувь нь ирэх 6 сарын хугацаанд америк долларын ханш өснө гэж үзэж байгаа бөгөөд ханшийн өсөлтийн хүлээлт нь жилийн өмнөхтэй ойролцоо байна. Хэрэглэгчид ирэх 6 сарын хугацаанд ам.долларын ханшийг дунджаар 2913 төгрөг байна гэж хүлээж байна. Энэ нь 2021 оны 2-р улирлын ам.долларын ханштай (2850 төгрөг) харьцуулахад 60 гаруй төгрөгөөр өндөр байна.


Зураг 2.2. Хүлээгдэж буй ам.долларын ханш, 6 сарын хугацаанд



Орон сууцны үнийн өөрчлөлтийн талаарх хүлээлтэд үндэслэсэн орон сууцны үнийн хүлээлтийн индексийг Зураг 2.3-т харууллаа. Орон сууцны үнийн хүлээлтийн индекс 1-ээс өндөр бол үнэ өснө гэсэн хүлээлт давамгайлж байгааг, 1-ээс бага бол үнэ буурна гэсэн хүлээлт давамгайлж байгааг харуулна. Энэ улиралд индексийн утга 1.8 болж өмнөх улирлаас эрс өссөн байна.

2021 оны 2-р улирлын байдлаар хэрэглэгчдийн дунд зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөхийг “мэдэхгүй” гэсэн хариулт 32.8 хувь буюу хамгийн их байна. Харин 15.0 хувь нь “зээлийн хүү өснө” гэсэн бол 23.2 хувь нь “буурна” гэж хүлээж байна. Ирэх нэг жилийн хугацаанд зээлийн хүү “өөрчлөгдөхгүй” гэсэн хариулт 28.9 хувь байна.


Зураг 2.3. Орон сууцны үнийн индекс



3. Худалдан авалтын төлөвлөгөө

Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний төлөвлөлтийг хоёр улирлын дараах ДНБ-ны өсөлтийн динамиктай харьцуулсныг зураг 3.1-д харууллаа. Эдгээр нь өсөлтийн трендтэй нэлээд ойрхон хамааралтай байгааг харж болно. Ялангуяа үл хөдлөх хөрөнгө болон автомашины худалдан авалтын төлөвлөлт нь ДНБ-ний өсөлттэй илүү ойрхон хувьсдаг байна.

Зураг 3.1. Нийт худалдан авалтын төлөвлөгөө




Тайлбар: Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлтийг улирлын нөлөөгөөр засварлаж тооцсон. Эдийн засгийн өсөлтийн тоон өгөгдлийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан: www.1212.mn.

2021 оны 2-р улирлын байдлаар ирэх хоёр улирлын том худалдан авалт 2020 оны мөн үе болон дундажтай харьцуулахад нэлээд буурахаар байна. Ийнхүү буурахад

автомашин, аялал жуулчлал, томоохон эд хогшил болон цахилгаан барааны эрэлт буурсан нь хамгийн их нөлөөлсөн. Ирэх зургаан сарын хугацаанд нийт иргэдийн 8.6 хувь нь машин, 5 хувь нь үл хөдлөх хөрөнгө, 9.2 хувь нь томоохон эд хогшил, цахилгаан бараа худалдан авах төлөвлөгөөтэй байна.

Автомашин эрэлт нь ДНБ-ний өсөлтийн хурдтай ойрхон хамааралтай хувьсдаг (Зураг 3.2-ын I хавтгай). Уг худалдан авалтын төлөвлөгөөнд монголд яваагүй боловч хуучин машины эрэлт хамгийн том хувь эзэлдэг. Автомашин худалдан авах эрэлт 2021 оны 2-р улиралд өмнөх оны мөн үе болон дунджаасаа нэлээд бага байна. Өмнөх оны мөн үеэсээ 5.4 пунктээр, 2014 оноос хойшхи дунджаасаа 6.7 пунктээр бага байна.

Зураг 3.2. Худалдан авалтын төлөвлөгөө, нэр төрлөөр



Тайлбар: Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлтийг улирлын нөлөөгөөр засварлаж тооцсон. Эдийн засгийн өсөлтийн тоон өгөгдлийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан: www.1212.mn.

2020 оны мөн үеийн түвшинтэй харьцуулахад 2021 оны 2-р улиралд үл хөдлөх хөрөнгийн эрэлт үл ялиг бага байна (Зураг 3.2-ын II хавтгай). Өмнөх оны мөн үеэсээ 0.8 пунктээр бага, 2014 оноос хойшхи дундаж түвшингээсээ 4 пунктээр бага байна.


Томоохон эд хогшил болон цахилгаан барааны эрэлт өмнөх оны мөн үеэсээ 3.3 пунктээр бага байна (Зураг 3.2-ын III хавтгай). 2020 оны туршид томоохон эд хогшил, цахилгаан барааны эрэлт дунджаар 12 хувьтай байсан бол 2021 оны 2-р улиралд 9.1 хувь байна.

Олон улсад тархаад буй Covid 19 цар тахалын дэгдэлттэй холбоотой хол хоригуудаас үүдэлтэйгээр 2020 оны 1-р улирлаас эхлэн аялал жуулчлалын эрэлт эрс буурсан (Зураг 3.2-ын IV хавтгай). 2021 оны 2-р улиралд аялал жуулчлалын эрэлт 21.1 хувь байгаа нь 2020 рны мөн үеэс 14 пунктээр бага байна.

4. Мөнгөн хөрөнгө хадгалах хэлбэр, зээлийн эрэлт

2021 оны 2-р улирлын байдлаар өнөөгийн нөхцөлд мөнгөн хөрөнгөө төгрөгөөр байршуулахыг илүүд үзэж буй хэрэглэгчдийн хувь 47.9 хувь байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 6.3 пунктээр бага, 2014 оноос хойшхи дундажтайгаа ойролцоо байна. Харин гадаад валютаар байршуулахыг илүүд үзэж буй хэрэглэгчдийн хувь 18.5 байгаа нь өмнөх оны мөн үеэсээ 1.5 пунктээр их, 2014 оноос хойшхи дундажтайгаа ойролцоо байна. Үл хөдлөх хөрөнгө хэлбэрээр байршуулахыг илүүд үзэж буй хэрэглэгчдийн хувь 25.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэсээ 2.5 пунктээр их харин 2014 оноос хойшхи дундажтай нь харьцуулахад 2.6 пунктээр бага байна.

Зураг 4.1. Мөнгөн хөрөнгө хадгалах хэлбэр




Тайлбар: Мөнгөн хөрөнгөө хадгалахыг илүүд үзэж буй хэлбэрүүд буюу төгрөг, гадаад валют, биет хөрөнгө зэргийн хувийг улирлын нөлөөгөөр засварлаж тооцсон. Бодит үйлчилж буй ханшны тоон мэдээллийг Монголбанкны цахим хуудаснаас авсан.

Зураг 4.1-ээс харахад төгрөгийн бодит үйлчилж буй ханш сулрах үед мөнгөн хөрөнгөө төгрөгөөр байршуулахыг илүүд үзэх хэрэглэгчдийн хувь өсч, гадаад валютаар байршуулах нь багасдаг. Төгрөгийн бодит үйлчилж буй ханш чангарах үед мөнгөн хөрөнгөө төгрөгөөр байршуулахыг илүүд үзэх хэрэглэгчдийн хувь буурч, гадаад валютаар байршуулах сонирхол нэмэгддэг.

2021 оны 2-р улирлын байдлаар зээлийн эрэлт 15.8 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үеэсээ 3.1 пунктээр өндөр, харин 2020 оны дундажтай ойролцоо байна. Автомашин, эд хогшил худалдан авах болон сургалтын гэх мэт хэрэглээний зориулалттай зээлийн эрэлт 3.1 хувь, үл хөдлөх хөрөнгийн зээл 3 хувь, харин бизнесийн зориулалттай зээл 3.3 хувь байна (Зураг 4.2-ын I хавтгай). Нийт иргэдийн 8.7 хувь нь цалин эсвэл тэтгэвэр барьцаалсан зээл, харин 8.3 хувь нь ямар нэг хөрөнгөө барьцаалсан зээл авах төлөвлөгөөтэй байна (Зураг 4.2-ын II хавтгай).

Зураг 4.2. Зээлийн төлөвлөгөө, зориулалт болон барьцаа



Тайлбар: Зээлийн төлөвлөгөөтэй холбоотой үзүүлэлтүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж тооцсон. Эдийн засгийн өсөлтийн тоон өгөгдлийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан: www.1212.mn.

5. Санхүүгийн итгэл

2019 оны 1-р улирлаас эхлэн санхүүгийн итгэлийн индексийг хэмжиж эхэлсэн. Уг үзүүлэлтийг хэмжихдээ хөрөнгийн бирж, хувьцаат компани, арилжааны банк зэрэг санхүүгийн байгууллагуудад хэр итгэдэг эсэхийг асууж тооцоолдог. Эдгээр санхүүгийн байгууллагуудаас гадна Засгийн газарт итгэх итгэлийг асууж хэмждэг.


Санхүүгийн итгэлийн индексийн динамикуыг зураг 5.1-т харууллаа. 2021 оны 2-р улирлын байдлаар судалгаанд хамрагдсан иргэдийн 40.8 хувь нь Засгийн газарт итгэж байгаа бол 50.4 хувь нь итгэхгүй байна. Засгийн газарт итгэдэг иргэдийн түвшин 2020 оны мөн үеэсээ 16 пунктээр бага, дунджаасаа 15 орчин пунктээр бага байна. Итгэдэггүй гэсэн иргэдийн хувь мөн төдий хэмжээгээр өссөн байна.

Иргэдийн санхүүгийн итгэх итгэл хамгийн өндөр байдаг байгууллага нь арилжааны банк байна. 2021 оны 2-р улиралд иргэдийн 68.2 хувь арилжааны банкинд итгэдэг, 24.8 хувь нь итгэхгүй байна. Итгэдэг иргэдийн хувь 2020 онтой харьцуулахад тогтвортой байна.

Арилжааны банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд итгэх итгэл тийм ч өндөр байдаггүй байна. Тухайлбал, хөрөнгийн бирж болон хувьцаат компанид итгэх итгэл банктэй харьцуулахад бараг хоёр дахин бага байдаг аж. 2021 оны 2-р улиралд хөрөнгийн биржэд итгэх итгэл 32.8 хувь, хувьцаат компанид итгэх итгэл 44.7 хувь байна. Энэ түвшингүүд нь 2020 оны мөн үеийн түвшингээсээ бага зэрэг

өссөн байна. Хөрөнгийн бирж болон хувьцаат компанид итгэдэг үү гэсэн асуултанд иргэдийн нэлээд өндөр хувь нь мэдэхгүй гэж хариулдаг.

Зураг 5.1. Санхүүгийн итгэлийн индекс



ДҮГНЭЛТ

2021 оны оны 2-р улирлын судалгаанаас харахад хэрэглэгчдийн итгэлийн ерөнхий индекс өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Энэ улиралд хэрэглэгчдийн өнөөгийн байдлын үнэлгээ бага зэрэг өсч, ойрын ирээдүйн талаарх хүлээлт бага зэрэг мууджээ. Ирээдүйн хүлээлтийн индексийн бууралтад ажлын байрны олдоц муудна гэсэн хүлээлт нөлөөлжээ.

2021 оны 2-р улирлын байдлаар ирэх зургаан сарын хүлээгдэж буй инфляци 9.2 хувь, харин ирэх нэг жилийн хүлээгдэж буй инфляци 11.4 хувь байна. Мөн хэрэглэгчид 2021 оны 4-р улирлын байдлаар ам долларын ханшийг 2913 төгрөг болно гэсэн хүлээлттэй байна.

2021 оны 2-р улиралд томоохон худалдан авалтын эрэлт 2020 оны мөн үе болон дундажтай харьцуулахад нэлээд буурсан. Үүнд автомашин болон томоохон эд хогшил, цахилгаан барааны эрэлт буурсан нь нөлөөлсөн.

Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл 2019 болон 2020 оны түвшинтэй харьцуулахад тогтвортой байна. Засгийн газарт итгэх итгэл 2020 оны болон өмнөх улирлын түвшингээсээ буурчээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Conference Board, 2000 “Consumer Confidence Survey”
2. Jeff Dominitz, Charles F.Manski “How should we measure consumer confidence?” The Journal of Economic Perspectives, Vol.18, No 2, pp 51-66
3. ҮСХ-ны мэдээллийн цахим хуудас www.1212.mn